

ХЯТАДЫН ОЛОН УЛСЫН СТРАТЕГИ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН (Танилцуулга)

Л.БЭГЗЖАВ

Хятадын олон улсын стратеги судлалын хүрээлэн (ХОУССХ) бол олон улсын стратегийн асуудлыг судлах Бүх Хятадын хэмжээний шинжлэх ухааны байгууллага юм. Одоогоос 20 жилийн өмнө, 1979 оны 10-р сард Бээжингийн олон улсын стратеги асуудлыг судлах хүрээлэн гэж байгуулагдаж, 1992 оны 10-р сард одоогийн нэрээрээ нэрлэгдсэн байна. Хүрээлэнгийн анхны захирлаар ХАЧА-ийн жанжин штабын орлогч дарга байсан У Сюцюань 10 жил ажилласан юм. Тэрбээр 1952 онд Хятадын Гадаад явдлын Яамны орлогч сайд байхдаа Монгол улсын Ерөнхий сайд маршал Х.Чойбалсанг оршуулах ёслолд оролцож байлаа. Одоогийн захирал нь Сюн Гуанкай юм.

Тус хүрээлэнгийн үйл ажиллагааны гол зорилго гэвэл

-олон улсын стратеги, аюулгүй байдал, дэлхийн улс төр, эдийн засгийн ба бүс нутгийн чанартай асуудлыг судлах

-дотоод, гадаад дахь олон улс судлал, стратеги судалгааны байгууллага, хамт олон, хүмүүстэй харилцаа тогтоох, эрдэм шинжилгээний талаар хамтран ажиллах.

-Хятадын засгийн газрын холбогдох яам, арми, үйлдвэр аж ахуйн газарт мэдээ материал нийлүүлэх, улс төрийн санал дүгнэлт гаргах, улмаар судалгааныхаа үр дүнг хариуцах

-Хятадын аюулгүй байдал, эдийн засгийн бүтээн байгуулалтанд хувь нэмэр оруулах

-олон улсын аюулгүй байдал, дэлхийн энх тайван, хөгжил дэвшлийн төлөө үйл ажиллагаагаа зориулах явдал юм.

Хүрээлэнгийн дээд удирдлага нь Удирдах зөвлөл юм. Удирдах зөвлөлөөс хүрээлэнгийн захирал, орлогч захирлыг сонгож, захирал, орлогч нарийн бичгийн дарга нар өдөр тутмын ажлаа хариуцдаг байна. Тус хүрээлэнгийн захиргаа, судалгааны алба, хэвлэн найруулах хэлтэс, номын сан, мэдээлэл лавлагааны хэлтэс зэрэгт 100 гаруй эрдэм шинжилгээний ажилтан ажилладаг. Тус хүрээлэнд цэргийн алба хааж буй болон чөлөөнд гарсан цэргийн хүмүүс, дипломат ажилтан, мэргэжилтэн, эрдэмтдийг урилгаар ажиллуулдаг системтэй. Тэднийг эрдэм шинжилгээний тэргүүлэх, дэд, туслах ажилтан гэж хуваах бөгөөд олон улс судлал, стратегийн асуудлаар мэргэжсэн хүмүүсийг тусгай урилгаар зөвлөхөөр ажиллуулдаг байна.

Хүрээлэнгийн судалгааны сэдвийг олон улсын стратеги байдлын хувирал, Засгийн газрын холбогдох яам, цэрэг, аж ахуйн байгууллагын хэрэгцээ шаардлагыг үндэслэн тогтоож, судалгааны үр дүнг холбогдох яам, газарт хүргүүлдэг байна. Хүрээлэнгийн ажилтнууд тодорхой сэдвээр

судалгаа явуулж эрдэм шинжилгээний сэдэв, илтгэл, өгүүлэл байнга бичиж, нийтлүүлдэгээс гадна эрдэм шинжилгээний ном товхимол байнга хэвлэн гаргадаг.

Хятадын олон улсын стратеги судалгааны хүрээлэнгээс эрхлэн "Олон улсын стратеги судлал" гэдэг сэтгүүлийг улирал тутам, хятад, англи хэл дээр хэвлэж дотоод, гадаадад тараадаг юм.

Монголын холбогдох судалгааны газрууд, түүний дотор тус Зүүн хойт Ази судлалын төв, энэ сэтгүүлийг хүлээн авч, судалгаа шинжилгээний ажилдаа ашигладаг юм.

Хятадын энэ хүрээлэн дэлхийн олон орны судалгааны байгууллага хувь хүмүүстэй харилцаж, эрдэм шинжилгээний солилцоо хийдэг байна. Одоо тус хүрээлэн 30 гаруй орны олон улс судлал, стратеги судалгааны 70 гаруй эрдэм шинжилгээний байгууллагатай байнгын харилцаатай, олон орны улс төрч, дипломатч, цэргийнхэн, эрдэмтэдтэй байнгын холбоотой ажиллаж байна. Харилцан айлчлал, хоёр талын болон олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, эрдэмтэд, ном хэвлэл, сэтгүүл харилцан солилцох зэргээр олон хэлбэрийн эрдэм шинжилгээний солилцоо хийж, улс түмний харилцан ойлголцол, найрамдлын үйлст тус хүрээлэн жинтэй хувь нэмрээ оруулж байдаг юм.

Хүрээлэнгийн хаяг нь:

Хятад улс. Бээжин хот. Чаоян дүүрэг.

Сяогуанлу хуаян бэйли 6 тоот.

индекс 100029, шуудангийн хайрцаг

Бээжин - 9812